



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 0132

Улаанбаатар хот

**Нийслэлийн Улсын Бүртгэлийн
газрын данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 24,552,000 /хорин дөрвөн сая таван зуун тавин хоёр мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн Улсын Бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Улсын Бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 12 дугаар
 сарын 24 өдрийн А/БЗД тоот тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Улсын Бүртгэлийн газар

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага		
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр	
1	Мэдээллийн самбар	хятад	1.2*2.4 хэмжээтэй акрелан самбар	2019	сайн	ш	14	858,000.0	12,012,000.0	Азийн хөгжлийн сан	Швейцарийн Хөгжлийн Агетлагийн буцалтгүй тусламж	
Бусад үндсэн хөрөнгийн дүн									12,012,000.0			
2	LED мэдээллийн самбар	хятад		2019	сайн	ш	20	302,500.0	6,050,000.0			
3	Дарааллын дугаар тараагч машин	хятад		2019	сайн	ш	2	2,695,000.0	5,390,000.0			
4	Дуудах программын машин	хятад		2019	сайн	ш	20	55,000.0	1,100,000.0			
Машин тоног төхөрөмжийн дүн									12,540,000.0			
Нийт бүртгэх хөрөнгийн дүн									24,552,000.0			